



Хамгийн өргөн сүлжээтэй төлбөрийн гарц



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

Нэр	Тайлбар
Нууцлалын түвшин	Нээлттэй
Хуудасны тоо	1
Хавсралтын тоо	
Хамрах хүрээ	Байгууллагын бүх ажилтан, гэрээт ажилтан, Харилцагч байгууллагууд
Хяналт тавих алба нэгж/ажилтан	Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал

Баримт бичгийн хувилбар						
№	Хувилбар	Боловруулсан/Засварласан		Хянасан		Огноо
		Албан тушаал, Овог нэр	Гарын үсэг	Албан тушаал, Овог нэр	Гарын үсэг	
1	2.0	МАБ хариуцсан захирал Ц.Гомбодорж		Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмохч		2024-12-26
2						
3						

Улаанбаатар хот
2024 он



Хамгийн өргөн сэржээтэй төлбөрийн гарч

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү бодлого нь “ККТТ” ХХК -ны мэдээлэл, мэдээллийн системийн нууцлал (confidentiality), бүрэн бүтэн байдал (integrity), хүртээмж (availability) байдлыг хангахад оршино.

ХОЁР. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОРИЛТУУД

- 2.1. Мэдээллийн аюулгүй байдлын холбогдох хууль, дүрэм, зохицуулалтыг дагаж мөрдөх;
- 2.2. Мэдээллийн зөвшөөрөлгүй хандалт, өөрчлөлт, устгалт хийх эрсдэлээс хамгаалах;
- 2.3. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилт, үр дүнг жилд хамгийн багадаа нэг удаа тооцож сайжруулалт хийх;
- 2.4. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар жилд хамгийн багадаа нэг удаа хийлгэж тайланг нээлттэй нийтлэх;
- 2.5. Харилцагч, хэрэглэгчийн хүлээлт, итгэлцэл, сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээ, систем, дэд бүтцийн хэвийн тасралтгүй ажиллагааг 99,8% -д хүргэх;
- 2.6. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд олон улсын сайн туршлага, стандартыг /ISO27001:2022 г.м/ оновчтой нэвтрүүлэх;
- 2.7. Нийт ажилтнуудыг сургалт, мэдээллээр байнга хангаж, мэдлэг ойлголтыг хөгжүүлэх;

---oo0oo---